



МОНГОЛ УЛС
ДОРНОД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2025 оны 02 сарын 06 өдөр

Дугаар 1177

Чойбалсан

Г “Цэцэрлэгийн багш” болзолт уралдаан Г
зохион байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 60.1.3, 60.1.5, Боловсролын ерөнхий хуулийн 30 дугаар зүйлийн 30.1.7, Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.2, Багшийн хөгжлийг дэмжих тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.2, 6 дугаар зүйлийн 6.1 дэх заалт, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2020 оны 01 дүгээр тогтоолоор батлагдсан “Дорнод аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”-ийн 3.1.3, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2024 оны 3 дугаар хуралдааны 03/02 дугаар тогтоолоор батлагдсан “Дорнод аймгийн 2025 оны Хөгжлийн жилийн төлөвлөгөө”-ний 1.1.2, тус хуралдааны 03/04 дүгээр “Аймгийн 2025 оны төсөв батлах тухай” тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Сургуулийн өмнөх боловсролын байгууллагын багш нарыг дэмжих “Цэцэрлэгийн багш” болзолт уралдааны удирдамжийг нэгдүгээр хавсралтаар, үйл ажиллагааны төсвийн задаргааг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2.Арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах 80.000.000 (наян сая) төгрөгийг аймгийн Орон нутгийн төсвийн 2.5 дахь заалт Төрийн албан хаагчдын нийгмийн баталгааг дэмжих болзолт уралдааны зардлаас санхүүжүүлэхийг аймгийн Засаг даргын тамгын газрын дарга (П.Бат-Өлзий)-д зөвшөөрсүгэй.

3.Аймгийн Боловсролын газар (Ч.Ариунаа)-тай байгуулах “Орон нутгийн төсөв”-өөс дэмжлэг үзүүлэх гэрээг боловсруулан батлуулж, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтэс (Б.Нарангэрэл), Санхүү төрийн сангийн хэлтэс (В.Цэнгэлмаа) -т тус тус даалгасугай.

4. Болзолт уралдааныг удирдамжийн дагуу чанартай зохион байгуулж, үр дүнг олон нийтэд танилцуулж ажиллахыг аймгийн Боловсролын газар (Ч.Ариунаа)-т даалгасугай.

5.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (Ч.Ганбат)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

ШЕЛ



2125010161

Аймгийн Засаг даргын 2023 оны
02 дүгээр сарын 06-ны өдрийн
147 дугаар захирамжийн нэгдүгээр
хавсралт

**ТӨРИЙН АЛБАН ХААГЧДЫН НИЙГМИЙН БАТАЛГААГ ДЭМЖИХ
БОЛЗОЛТ УРАЛДААНЫ УДИРДАМЖ**

Зорилго: Боловсрол, Шинжлэх Ухааны сайдын 2021 оны А/07 дугаар тушаалаар батлагдсан “Чадварлаг багш” арга хэмжээ, сургуулийн өмнөх боловсролын багш, багшийн туслахын хөдөлмөрийн үнэлэмж, мэргэжлийн нэр хүндийг дээшлүүлэх, нийгмийн хамгааллыг дэмжих, боловсролын олон талт үйл ажиллагаанд цэцэрлэгийн багш нарыг хамруулах, багшлахуйн ур чадвар, санал, санаачилгыг дэмжин урамшуулах, хүүхэд бүрийн хөгжлийг дэмжих шилдэг арга зүй, тэргүүн туршлагыг түгээн дэлгэрүүлэхэд оршино.

Хэрэгжих хугацаа: 2025 оны 02 дугаар сарын 01-ны өдрөөс 05 дугаар сарын 30-ны өдөр

Хамрах хүрээ: Дорнод аймгийн сургуулийн өмнөх боловсролын багш, багшийн туслах

Шагналын сан: 80,000 сая төгрөг

Санхүүжилтын эх үүсвэр: Орон нутгийн төсөв

Оролцогч багш нарт тавих нийтлэг шаардлага:

1. Мэргэжлээрээ тогтвор суурьшилтай 5-аас дээш жил ажилласан байх
2. Багш мэргэжлийн ёс зүйг чанд сахин баримталдаг байх
3. Багш мэргэжлийн нэр хүнд, үнэлэмжийг өндөрт өргөдөг байх
4. Хүүхдийг хүмүүжүүлэх, төлөвшүүлэх чиглэлээр санал, санаачилгатай ажилладаг байх
5. Сургалтад мэдээлэл, харилцааны технологийг бүтээлчээр ашиглах чадвартай байх
6. Цэцэрлэг, хамт олон, сурагч, эцэг эх, олон нийтэд ажил, амжилтаараа танигдаж, хүлээн зөвшөөрөгдсөн байх
7. Эцэг эх, асран хамгаалагчдын идэвх оролцоог нэмэгдүүлэх, эцэг эх, асран хамгаалагч нэг бүртэй ажилладаг туршлагатай байх
8. Боловсрол судлал, хүүхдийн сэтгэл зүй, хүүхэд хамгаалал, тэгш хамруулах боловсрол, тогтвортой хөгжлийн боловсролын талаар сургалт зохион байгуулахад хамтран оролцсон туршлагатай байх

Оролцогчдыг бүртгэх: “Нийтлэг шаардлага”-ыг хангасан багш бүр оролцох эрхтэй бөгөөд 2025 оны 2 дугаар сарын 01 өдрөөс 03 дугаар сарын 01-ний хооронд бүртгэнэ. Бүртгүүлэхдээ танилцуулга бичлэгийг 3 минутад багтаан, Youtube-д байршуулсан линкийг хуулж, тухайн үед өгсөн холбоосоор хугацаандаа бүртгүүлнэ.

Танилцуулгын бүтэц:

1. **Эхний хэсэг:** Цэцэрлэгийн багш мэргэжлийн онцлог, давуу тал, энэхүү мэргэжлийн сонгох үндэслэл, шалтгаан, бага насны хүүхдийн бие бялдар, оюун ухаан, нийгэмшихүйн хөгжилд оруулах хувь нэмэр;
2. **Дунд хэсэгт:** Бүлгийн хүүхдийн хөгжлийн явц, хүүхдийн ялгаатай хэрэгцээнд тулгуурлан сургалт, үйл ажиллагааг зохион байгуулж байгаа байдал, бүлгийн менежмент төлөвлөлт, хүүхдийн хөгжлийн үнэлгээ ахиц, амжилт;
3. **Төгсгөл хэсэгт:** Өөрийн сайн туршлага арга зүйгээ аймаг, бүс цэцэрлэгийн хэмжээнд түгээн дэлгэрүүлж хуваалцсан, багаар хамтран ажилласан, тэдний хөгжлийг дэмжсэн үйл ажиллагаанд оролцсон байдал;

НЭГДҮГЭЭР ШАТ

Хугацаа: 2025 оны 3 дугаар сарын 01-ний өдрөөс 03 дугаар сарын 15-ны хооронд

Танилцуулга, бүрдүүлсэн баримт нотолгоог үндэслэн, анхан шатны шалгаруулалтаар 60 хувиас дээш гүйцэтгэлтэй багш нар дараагийн шатанд оролцох эрхтэй болно. Шаардлагатай тохиолдолд нэр дэвшигч багш болон сургалтын байгууллагатай холбогдож нэмэлт мэдээллийг тодруулна.

Шалгуур:

1. Танилцуулгын бүтэц /3 хэсэг/
2. Контентын шаардлага хугацаа, дуу, дүрс /2-3 минут/
3. Цэцэрлэгийн багш мэргэжлийн онцлог, давуу тал, энэхүү мэргэжлийн сонгох, үндэслэл, шалтгаан, үнэлэмж, бага насны хүүхдийн бие бялдар, оюун ухаан, сэтгэцийн хөгжилд оруулах хувь нэмэр;
4. Цэцэрлэг, бүлгийн хүүхдийн хөгжлийн явц, хүүхдийн ялгаатай хэрэгцээнд тулгуурлан сургалт, үйл ажиллагааг зохион байгуулж байгаа байдал, бүлгийн менежмент төлөвлөлт, хүүхдийн хөгжлийн үнэлгээ ахиц, амжилт;
5. Аймаг, бүс, цэцэрлэгийн мэргэжил нэгт багш нарт сайн туршлагаа хуваалцсан, багаар хамтран ажилласан, тэдний хөгжлийг дэмжсэн үйл ажиллагаанд оролцсон байдал

ХОЁРДУГААР ШАТ

Хугацаа: 2025 оны 03 дугаар сарын 20-ны өдрөөс 05 сарын 30-ны өдөр

Шүүгчдээс өгсөн ур чадварын тухайн даалгаварт 60 хувиас дээш гүйцэтгэлтэй багш нар дараагийн шатанд орох эрх үүснэ.

Шалгуур:

1. Бүтээлч сэтгэлгээний арга барил хэрэглэх, асуудал шийдвэрлэх чадвар /Сургалтын хөтөлбөр, төлөвлөлт, хэрэгжилт, үр дүн, хүүхдийн онцлог, ялгаатай байдалд тохируулан сургалтын арга зүйг оновчтой хэрэгжүүлж буй байдал/
2. Хүүхдийн хөгжлийн үнэлгээ, ахиц амжилт, үнэлгээний баримтжуулалт, сайн туршлага арга зүйг заах аргын нэгдэл, эцэг эхэд танилцуулсан байдал, багшийн гүйцэтгэлийн үнэлгээний үр дүн анализ, цаашдын төлөвлөлт;
3. Сургалт, үйл ажиллагаанд цахим технологийг нэвтрүүлж байгаа байдал, цахим сургалт болон хэрэглэгдэх бүрдүүлсэн байдал, эцэг эхэд хүүхдийн насны онцлог, хүүхэдтэй ажиллах арга барил, сурган хүмүүжүүлэх чиглэлээр зөвлөмж зөвлөгөө боловсруулж хүргүүлсэн байдал түүний ашиглалт, хэрэглээ;
4. Төрийн албан хаагчийн ур чадвар /Мэдлэгийн түвшин/
5. Өөрийгөө хөгжүүлэх төлөвлөгөөний хэрэгжилт үр дүн, цаашдын зорилго, манлайлах чадвар хийж хэрэгжүүлсэн сайн туршлага, нийгэмд нөлөөлөх манлайллын ур чадвар гэсэн 5 үзүүлэлтээр дүгнэнэ.

Шүүгчдийн бүрэлдэхүүн: Монгол Улсын Боловсролын Их сургууль, Аймгийн Засаг даргын Тамгын газар, Боловсролын газар, МУИС-ийн Зүүн бүсийн сургууль, төрийн бус байгууллагын төлөөлөл бүхий 5-7 хүний бүрэлдэхүүнтэй байх бөгөөд шалгуур бүрд шүүгчдийн бүрэлдэхүүн өөрчлөгдөнө.

Урамшуулал: Уралдааны үе шатуудад цуглуулсан оноо болон олон нийтийн санал асуулгаар хамгийн өндөр оноо авсан 2 багш, 1 багшийн туслахыг тус бүр 20,0 сая төгрөгөөр урамшуулна.

Уралдаанд хамгийн өндөр оноогоор шалгарсан 2 багш, 1 багшийн туслахад орон сууцны урьдчилгаа төлбөрт дэмжлэг үзүүлнэ. Шалгарсан багш, багшийн туслахад урамшууллын батламж гардуулан, дэмжлэгийг зориулалтын дагуу гэрээг үндэслэн шилжүүлнэ.

Хүлээгдэж буй үр дүн:

- Мэргэжлийн тасралтгүй хөгжилд багш, багшийн туслахын манлайлал хөгжсөн байна.
- Багш, багшийн туслахын сайн туршлага, санал санаачилга, бүтээлч үйл ажиллагааг сурталчилсан байна.
- Багш, багшийн туслахын нийгмийн асуудлыг шийдвэрлэнэ.
-

Түгээн дэлгэрүүлэлт: Улс, аймгийн хэмжээнд Дорнод аймгийн Засаг даргын тамгын газрын цахим сайт, Боловсролын газрын dornodedu.mn цахим сайт, Боловсролын газрын пэйж хуудсаар түгээн дэлгэрүүлж, сурталчилна. Сүүлийн шатанд шалгарсан 2 багш, 1 багшийн туслахын хөрөг нэвтрүүлэг хийж, олон нийтэд түгээнэ.

ЕРӨНХИЙ ЗОХИОН БАЙГУУЛАГЧ:


Аймгийн засаг даргын тамгын газар,
Боловсролын газар

ХАМТРАН ЗОХИОН БАЙГУУЛАГЧ:

Сургуулийн өмнөх боловсролын байгууллагууд
Хэвлэл, мэдээллийн байгууллагууд

---oOo---

Аймгийн Засаг даргын 2023 оны
 02 дүгээр сарын 06-ны өдрийн
 177 дугаар захирамжийн хоёрдугаар
 хавсралт



“ЦЭЦЭРЛЭГИЙН БАГШ” БОЛЗОЛТ УРАЛДААНЫ
 ТӨСВИЙН ЗАДАРГАА

№	Зорилт	Хамрах хүрээ	Багшийн тоо	Шагнал	Нийт
1	Төрийн албан хаагчдын нийгмийн баталгааг дэмжих болзолт уралдааны шагнал	СӨБ-ын багш	2	20,000,000	40,000,000
2	Уралдааны сүүлийн шатны оролцогчдын урамшуулал /багш -3/		3	3,000,000	9,000,000
3	Төрийн албан хаагчдын нийгмийн баталгааг дэмжих болзолт уралдааны шагнал	СӨБ-ын туслах багш	1	20,000,000	20,000,000
4	Уралдааны сүүлийн шатны оролцогчдын урамшуулал /туслах багш -3/		3	3,000,000	9,000,000
5	Үйл ажиллагааны зардал		1	2,000,000	2,000,000
	НИЙТ				80,000,000

---oOo---